



УВС АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ САРЫН ТАНИЛЦУУЛГА

2015/10



Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг **uvs.nso.mn** хаягаар орох болон аймгийн ЗДТГ-т байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- + Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- + Ажиллах хүчний үр дүнгийн танилцуулга
- + Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- + 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн,сум,багаар
- + Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2010 он
- + 2013 оны ХАА-н салбарын танилцуулга,
- + 2013 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- + 2013 оны Аймгийн үйлдвэр,үйлчилгээний салбарын танилцуулга
- + 2014 оны ХАА-н салбарын танилцуулга
- + 2014 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- + 2014 оны Аж үйлдвэр,барилга,үйлчилгээний салбарын танилцуулга
- + 2014 оны ажил эрхлэлтийн байдлын танилцуулга

Улс, аймгийн мэдээлэл авах хаяг:uvs.nso.mn

www.uvs.gov.mn

Мэдээллийн сангаас авах бол: www.1212.mn, www.toollogo2010.mn

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

uvs@nso.mn/ албаны хаяг /

Утас: 70453316, 70452322

АГУУЛГА

Хэрэглэгчдэд лавлагаа	2
Аргачлалын тайлбар	4
III. Хүн ам	
3.1 Хүн ам	5
IV Хөдөлмөр	
4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд	5-9
VI. Нийгмийн даатгал, халамж	10-12
VIII. Эрүүл мэнд	12-17
XI. Байгаль орчин	
11.1 Цаг уурын байдал	17
11.2 Аюулт үзэгдэл, ослын мэдээ	17-18
XII. Гэмт хэрэг, шүүх	18-20
XIV. Мөнгө, банк, даатгал	20-21
XV. Төрийн санхүү	
15.1 Орон нутгийн төсвийн орлого	22-23
15.1 Орон нутгийн төсвийн зарлага	24-25
15.1 Төсөвт байгууллагуудын өглөг авлага	25
XVI. Гадаад худалдаа	26
XVII. Үнэ	26-31
XVIII Хөдөө аж ахуй	
18.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ	31-32
18.2 Үр тариа, төмс, хүнсний ногоо, байгалийн хадлан бэлтгэл	32 – 33
18.3 Үр тариа, төмс, хүнсний ногоо тариалалт	33 - 34
XIX Аж үйлдвэр	34-39

Хүснэгтэн мэдээллүүд

Аймгийн үндсэн үзүүлэлт	40-41
IV Хөдөлмөр	42-45
VI. Нийгмийн даатгал, халамж	46-48
VIII. Эрүүл мэнд	49-51
XI. Байгаль орчин	52
XII. Гэмт хэрэг, шүүх	53-55
XIV. Мөнгө, банк, даатгал	55-58
XV. Төрийн санхүү	59-61
XVI. Гадаад худалдаа	62
XVII. Үнэ	63-65
XVIII Хөдөө аж ахуй	65-66
XIX Аж үйлдвэр	67-69

Аргачлалын тайлбар:**ОРОН НУТГИЙН ТӨСӨВ**

Төсвийн орлого зарлагын тооцоог Олон улсын Валютын сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн орлого, үүнээс улсын төсөвт /аймгийн/ төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа. Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2012 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 213 нэр төрөл болгож 2010 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)–ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно

ХАА-н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс: Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс: Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс : Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй

Д - дахин


3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.



III ХҮН АМ


2015 оны эхний 10 сард 1650 эхээс 1661 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 136 – аар буюу 7.6 хувиар буурсан байна.

Гэрийн төрөлт 13 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 хүүхдээр бага байна.



Хүн амын төрөлтийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 4.0 хувиар буурсан байна.

Хүн амын нас баралт 379 гарч өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хувиар буурсан бөгөөд 1000 хүнд 5.0 ноогдох болсон нь ноднингийн мөн үеэс 0.2 промилээр бага байна. Нийт нас баралтын 16.1 хувийг эмнэлэгийн нас баралт эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 0.2 пунктээр буурсан байна. Хүн амын нас баралтын тоо өмнөх 4 жилийн дунджаас 1.1 хувиар өссөн байна.



2015 оны 10 сард 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт 17.0 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.9 промилээр, өмнөх 4 жилийн дунджаас 1.2 промилээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.



IV ХӨДӨЛМӨР

4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1056 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 26.6 хувиар буюу 222 хүнээр өсч, өмнөх сараасаа 7.2 хувиар буюу 82 ажилгүй иргэдээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 639 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 60.5 хувийг эзэлж байна.




Оны эхний 10 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 14.2 хувиар буюу 131 ажилгүйчүүдээр нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 1.0 хувь нь буюу 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст 10-р сард 322 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан ажилгүйчүүдээс 91 иргэн ажилд зуучлагдан орж, 313 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 35.0 хувь нь 15-24 насны, 36.8 хувь нь 25-34 насны, 17.4 хувь нь 35-44 насны, 10.7 хувь нь 45-59 насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 28.5 хувь нь дээд, 15.4 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 46.3 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 9.8 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролын түвшингээр




16-аас дээш насны арван мянган хүнд 218 ажилгүйчүүд ноогдож байна.

2015 оны эхний 10-р сарын байдлаар 1092 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24.3 хувиар буурчээ.

Хөдөлмөр



Ажлын байрны захиалга эдийн засгийн ангиллаар авч үзэхэд 4.7 хувийг ХАА, ойн аж ахуй, ан агнуур, 14.8 хувийг уул уурхай, 11.3 хувийг барилга, 13.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.2 хувийг худалдаа, 0.6 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 1.3 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, 7.1 хувийг боловсролын салбар, 34.8 хувийг үйлчилгээний бусад салбар, 0.4 хувийг урлаг, үзвэр, тоглоомын салбар, 1.6 хувийг эрүүл мэндийн салбар, 0.8 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 1.5 хувийг зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, 2.0 хувийг олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарууд эзэлж байна.




Ажлын байрны захиалгыг өнгөрсөн оны мөн үетэй харицуулахад ХАА салбар 79.0 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 48.8 хувиар, барилгын салбар 44.3 хувиар, худалдааны салбар 86.6 хувиар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 60.0 хувиар, санхүү болон даатгалын салбар 63.2 хувиар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбар 51.7 хувиар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 30.4 хувиар, боловсрол 19.8 хувиар, эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар 55.0 хувиар тус тус буурч, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 3.8 дахин, уул уурхай олборлолт 4.8 дахин, тээврийн салбар 1.5 дахин, усан хангамж 1.8 дахин тус тус өссөн байна.

2015 оны 1000 ажлын байр шинээр бий болгох зорилттойгоос 1251 шинэ ажлын байр бий болж зорилтын биелэлт 125.1 хувьтай байна. Ажлын шинэ байранд орсон иргэдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.1 хувиар буурсан байна.


Шинэ ажлын байранд орсон хүмүүсийн 1.4 хувь нь менежер, 2.8 хувь нь мэргэжилтэн, 5.0 хувиар техникч болон туслах, 5.7 хувь нь ХАА, ойн аж ахуйн, 29.4 хувь нь худалдаа, 18.5 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 13.3 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын ажилтан, 11.1 хувь нь машин механизмын операторч, угсрагчийн ажилд, 11.6 хувь нь энгийн мэргэжлээр ажилд орсон байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон хүмүүс, ажил мэргэжлийн ангиллаар, бүтцээр



Шинэ ажлын байранд орсон иргэдийн 29.7 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 11.4 хувийг барилга, 13.3 хувийг худалдаа, 1.6 хувийг тээвэр, 19.7 хувийг ХАА, ойн аж ахуйн, 1.0 хувийг мэдээлэл, холбоо, 2.2 зочид буудал, нийтийн хоолын үйлчилгээ, 2.2 хувийг боловсролын салбар, 0.9 хувийг эрүүл мэнд, 4.9 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар тус тус эзэлж байна.

Шинэ ажлын байранд ажилд орсон хүний тоо, эдийн засгийн салбарын ангилалаар, бүтцээр



Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн эдийн засгийн салбарын ангилалыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээвэр ба агуулахын салбар 6.6 дахин, боловсролын салбар 13.5 дахин, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 8.0 дахин, санхүү даатгалын үйл ажиллагаа 9.0 дахин, мөн ажил мэргэжлийн ангилалыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мэргэжилтэн 88.3 хувиар, техникч болон туслах ажилтан 6.8 дахин, контор, үйлчилгээний ажилтан 84.2 хувиар, суурин төхөөрөмж, машин механизмын угсрагч ажилтан 2.5 дахин, энгийн ажил мэргэжилтэй ажилд орсон иргэд 8.2 дахин, зэвсэгт хүчний ажил, мэргэжил 16.0 дахин тус тус өссөн байна.




VIII. ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 10 сарын байдлаар нэг хүртэлх насандаа 32 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхдээр буурч, 1 – 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс 3 хүүхдээр бага байна. Мөн жирэмслэлт болон төрөлтийн улмаас эхийн эндэгдэл гараагүй байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох/ Зүүнговь /285.7/, Түргэн /250.0/, Бөхмөрөн /200.0/, Наранбулаг /111.1/, Тэс /107.1/, Зүүнхангай /90.9/, Өндөрхангай /62.5/ Ховд /58.8/, Тариалан /52.6/, Баруунтуруун /29.4/ суманд байгаа нь аймгийн дунджаас 7.1 – 263.4 промилээр өндөр, Улаангом сум 5.8 промилээр бага бусад суманд гараагүй байна.




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 32 гарч, 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин 19.3 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.9 промилээр өссөн байна. Өмнөх 4 жилийн дунджаас нялхсын эндэгдлийн түвшин 0.4 промилээр өссөн бол 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 0.6 промилээр буурсан байна.




Нялхсын эндэгдэл Зүүнговьд 2, Өндөрхангай 2, Тариалан 2, Түргэн 1, Тэс 2, Ховд 1, Зүүнхангай 1, Наранбулаг 1, Улаангомд 20 тохиолдол гарч бусад сумдад гараагүй байна.

Осол гэмтлийн улмаас 47 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 689 болсон байна. Осол гэмтлийн улмаас нас барагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 5.4 хувиар буурсан бол өвчлөгчдийн тоо 6.0 хувиар өссөн байна.




Хорт хавдрын өвчлөл 164 болж нас баралт 133 гарсан байна. Хорт хавдрын улмаас нас барагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 20.5 хувиар, өвчлөгчдийн тоо 79.6 хувиар тус тус өссөн байна.




Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 473 болж өнгөрсөн оны мөн үеэс 10.0 хувиар буюу 43 гаралтаар өссөн байна. 2015 оны эхний 10 сард гарсан халдварт өвчний тоо өмнөх 4 жилийн эхний 10 сард гарсан халдварт өвчний дунджаас 21.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчний гаралт




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2015 оны эхний 10 сарын байдлаар,

нийт өвчинд эзлэх хувиар





Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин өмнөх оны мөн үед нийт халдварт өвчний 7.2 хувийг эзэлж байсан бол 2015 оны эхний 10 сарын байдлаар 2.8 пунктээр, салхинצעэг 13.0 пунктээр, БЗХӨ 2.2 пунктээр тус тус буурсан байна.



10000 хүн тутмаас 62.5 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Түргэн /114.0/, Улаангом /105.2/, Тариалан /67.3/ дунджаас 4.8 – 51.5 процедиимиээр дээгүүр Зүүнхангай /57.0/, Малчин /55.3/, Давст /51.0/, Тэс /45.5/, Бөхмөрөн /43.0/, Сагил /40.9/, Ховд /31.3/, Хяргас /30.3/, Цагаанхайрхан /24.9/, Наранбулаг /24.8/, Өмнөговь /23.9/, Өндөрхангай /23.1/, Зүүнговь /22.7/, Завхан /11.5/, Өлгий /9.3/, Баруунтуруун /8.2/ сумдад аймгийн дунджаас 5.5 – 54.3 процедиимиээр доогуур байна.



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 4.4 хувь нь гепатит, 47.1 хувь нь БЗХӨ, 12.1 хувь нь сүрьеэгээр, 0.6 хувь нь гахайн хавдраар, 35.7 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.



Өнгөрсөн оны мөн үеэс сүрьеэ 9, тэмбүү 23, гар хөл амны өвчин 17, улаанбурхан 108, хүйтэн 16, бруцеллез 1, бусад өвчин 2 гаралтаар тус тус нэмэгдсэн бол цусан суулга 3, гепатит 10, трихомониаз 28, гахай хавдар 12, суулгалт халдварт 24, салхинцэцэг 54, ёлом 2 гаралтаар тус тус буурсан байна.



Амбулаториор 278.6 мянган хүнд үзлэг хийгдэж, 15.6 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүн 8.1 мянган хүнээр өссөн бол хэвтэн эмчлүүлэгчид өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.0 мянган хүнээр буурсан байна.

Хувийн хэвшлийн 12 эмнэлгээр 2015 оны эхний 10 сард нийт 12.3 мянган хүнд үзлэг, эмчилгээ оношлогоо хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.2 мянган хүнээр бага байна. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний орлого 350.2 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 92.7 сая төгрөгөөр буюу 36.0 хувиар өссөн байна.



ХИ.БАЙГАЛЬ ОРЧИН

11.1 Цаг уурын байдал

Энэ оны 10 - р сард агаарын температур хамгийн ихдээ Давст, Зүүнговь, Тэс, Завхан, Улаангом сумдад 21.6-23.5 хэм халуун, хамгийн багадаа Өмнөговьд -22.7 хэм байсан байна. Баруунтуруун, Завхан, Зүүнговь, Давст, Наранбулаг сумдад дунджаар 3.2 хэмээс 5.3 хэм дулаан байсан байна. Хөрсний гадаргын дундаж температур Зүүнговь, Сагил, Завхан, Давст, Наранбулаг сумдад 5.4 хэмээс 7.5 хэм дулаан байлаа.

Салхины хамгийн их хурд Улаангом суманд 32 м/сек хүрсэн бөгөөд 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговьд 15, Завханд 11, Баруунтуруунд 10 өдөр байв.

Түргэнд 13.9, Зүүнхангайд 13.1, Улаангомд 10.4 мм хур тунадас орсон нь бусдаас илүү байна. Хур тунадастай өдөр Зүүнхангай, Өндөрхангайд 4-5 өдөр байлаа.

Цасны зузаан Түргэнд 8, Сагилд 3, Завхан, Өмнөговь, Улаангомд 2 см байсан байна.

Агаарын чанарын мэдээгээр хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй харин тоосны хэмжээ хүлцэх агууламжаас давсан тохиолдол 1 гарсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс агаарт байгаа хүхэрлэг хий 0.01 мг/м^3 аар, азотын давхар исэл 0.01 мг/м^3 аар бага, нүүрстөрөгчийн дутуу исэл 0.32 мг/м^3 аар илүү байлаа.

1.2 Аюулт үзэгдэл, ослын мэдээ

Гамшигтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд: -Энэ оны 10 дүгээр сард газар хөдлөлтийн аюулт үзэгдлийн тохиолдол 1, хүчтэй салхи шуурганы тохиолдол 1, үерийн аюулт үзэгдэл 1, ой хээрийн түймрийн тохиолдол 9, объектын гал түймрийн тохиолдол 18 гарсан байна.


- Тариалан сумын нутагт 3.7 магнитудын хүчтэй газар хөдлөлт болж газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас хохирол учраагүй байна. Ой хээрийн болон объектын түймрийн улмаас иргэд болон байгууллагад 83326.0 мянган төгрөгийн хохирол учирч 255433.0 мянган төгрөгийн хөрөнгийг авран хамгаалсан байна.



ХИИ ГЭМТ ХЭРЭГ

Энэ оны эхний 10 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 322 болж өнгөрсөн оны мөн үеэс 8.8 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 46 гэмт хэргээр буюу 16.7 хувиар тус тус өссөн байна.


Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эхний 10 сард, тоо



Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10.0, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 50.0 хувиар буурч, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 7.3, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3.4, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50.0 хувиар, хүн амын эрүүл мэндийн эсрэг

гэмт хэрэг 50.0, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 71.4 хувиар, хүүхэд гэр бүл,нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2.5 дахин өссөн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3.4 хувь өссөнөөс үүнээс нийт хулгайн гэмт хэрэг 14.8 хувиар өсчээ. Хулгайн гэмт хэргээс халаасны хулгайн хэрэг 3 дахин өсч, иргэдийн өмчийн хулгай 2.4, малын хулгай 6.7 хувиар буурчээ. Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хүнийг санаатай алах гэмт хэрэг 50.0, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 8.6 хувиар өссөн бол бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 60.0 хувиар буурсан байна.




Нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 158 тохиолдол гарснаас бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэргийн 70, өмчийн хулгайн 24 тохиолдол гарчээ. Гэмт хэргийн гаралт өнгөрсөн оны мөн үеэс Улаангом, Зүүнговь,Зүүнхангай, Тариалан, Наранбулаг, Сагил,Завхан сумдад 0.6 - 60.0 хувиар буурч, бусад сумдад 16.7 хувиас 1.5 дахин өссөн байна.

Энэ оны эхний 10 сард 314 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 5.4 хувь буюу 17 нь эмэгтэй хүн байна. Өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн тоо 11.0 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 335 иргэд, байгууллагад 662.9 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 23.0 хувиар өссөн байна. Иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 74.7 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэргийн улмаас 164 хүн гэмтэж, 13 хүн нас барсан байна.

Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 414.3 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.



Гэмт хэргийн 6.9 хувь нь гудамж талбайд, 28.3 хувь нь согтуугаар, 4.6 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэж үйлдэгдсэн гэмт хэрэг 44.4, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 21.1 хувиар буурсан байна.



XIV. Мөнгө, банк, даатгал

Монгол банкны эх үүсвэрээр 31.9 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 372.0 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 363.9 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөний 97.8 хувийг эргүүлэн татсан байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 18.3 тэрбум төгрөгөөр буюу 36.4 хувиар мөн гүйлгээнээс татсан мөнгө 1.0 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар тус тус буурсан бол гүйлгээнд гаргасан мөнгө 13.9 тэрбум төгрөг буюу 3.9 хувиар өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 161.3 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 4.3 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 4.9 тэрбум төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан бол хугацаа хэтэрсэн зээл 3.0 тэрбум төгрөгөөр буюу 3.3 дахин тус тус өссөн байна.

1141.1 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 912.5 сая төгрөгөөр буюу 5.0 дахин өссөн байна.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 35.9 тэрбум төгрөгөөр буюу 28.6 хувиар өссөн байна.

■ АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ /Арилжааны банкуудаар, сая төгрөг/





Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр Хаан, Хас банк тэргүүлж байгаа бөгөөд тэдгээрийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 79.8 хувьтай тэнцэж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.2 хувийг Төрийн банк, Хаан банк 1.1, Хас банк 0.8 хувь, 0.4 хувийг Капитал банкны хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.


Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 59.9 тэрбум төгрөг болсон байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.9 хувиар буюу 6.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 19.5 тэрбум төгрөгөөр буюу 48.5 хувиар өссөн байна.

Хадгаламжийн үлдэгдэл /сая.төгрөгөөр/





Арилжааны банкууд иргэд, аж ахуй нэгж нийт 69.7 мянган зээлдэгчид 124.3 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд төрлөөр нь авч үзвэл лизингийн зээл 2.4 хувь, хадгаламж барьцаалсан зээл 14.2 хувь, малчны зээл 15.7 хувь, бизнесийн зээл 20.1 хувь, орон сууц, хашаа байшингийн зээл 8.8 хувь, цалингийн зээл 19.7 хувь, тэтгэвэрийн зээл 13.2 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээлдэгчдийн тоо 10.2 хувиар өссөн бол зээлийн хэмжээ 8.9 хувиар буурсан байна.



XV ТӨРИЙН САНХҮҮ

15.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 10 сард аймгийн төсөвт 15.3 тэрбум төгрөг оруулахаас 14.6 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 94.9 хувьтай, 5.1 хувиар тасарлаа.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 7.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 7.3 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 92.6 хувиар биелүүлж 7.4 хувиар буюу 585.0 сая төгрөгөөр тасарч байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 1.6 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 1.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 94.8 хувиар биелүүлж 5.2 хувиар буюу 82.1 сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Аймгийн төсөвт өөрийн орлогоор 6.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 5.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 92.0 хувиар биелүүлж 8.0 хувиар буюу 503.7 сая төгрөгөөр тасалсан байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 1.5 хувиар буюу 110.1 сая төгрөгөөр их, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн орлого 6.7 хувиар буюу 107.2 сая төгрөгөөр бага, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 3.9 хувиар буюу 217.3 сая төгрөгөөр илүү байна.

2015 оны эхний 10 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө 13.2 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөвлөгөө 3.4, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 65.5 хувиар тус тус тасарч бусад орлогын төлөвлөгөө 108.1- 453.8 хувиар биелэгдсэн байна.

Мөн эхний 10 сард аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас орлого тодорхойлох боломжгүй иргэний орлого 10.6, цалингийн ашиг 5.9, үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 21.4, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 1.7, улсын тэмдэгтийн хураамж 33.1, газрын төлбөр 41.0, ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр 14.9, түгээмэл тархацтай ашигт малтмалын бусад нөөц ашигласны төлбөр 45.7, рашаан, ус ашигласны төлбөр 27.1, хог хаягдлын үйлчилгээний хураамж 29.7, хүү торгуулийн орлогын төлөвлөгөө 61.1 хувиар, нэр заагдаагүй орлогын төлөвлөгөө 26.7 хувиар тус тус тасарч бусад татваруудын орлогын төлөвлөгөө 6.6 хувиас 193.6 хувиар биелсэн байна.

Өнгөрсөн 2014 оны эхний 10 сарынхаас орлого тодорхойлох боломжгүй иргэний орлого 3.9, цалингийн ашиг 8.1, авто өөрөө явагч хэрэгслэлийн татварын орлого 4.3, газрын төлбөр 67.6, рашаан ус ашигласны төлбөр 1.9 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 91.9 хувиар илүү, бусад нэр төрлүүд бага байна.

Аймгийн төсвийн орлогын 61.8 хувийг тусламжийн орлогоор, 28.7 хувийг орлогын албан татвараар, 2.6 хувийг татварын бус орлогоор, 3.7 хувийг бусад татвар хураамжаар, 3.2 хувийг өмчийн татвараар бүрдүүлсэн байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад орлогын албан татварын эзлэх хувь 0.7 пунктээр өссөн байна.




Сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад аймгийн төсвийн орлогод эзлэх тусламжийн орлогын хувь 1.9 пунктээр өсч, орлогын албан татварын эзлэх хувь 1.8 пунктээр буурсан байна.

Аймгийн өөрөө бүрдүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 1.5 хувиар их, сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад 1.4 хувиар илүү байна.



Оны эхний 10 сард аймгийн төсвийн нийт зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 17.3 хувь болж сүүлийн 3 жилийн дунджаас 0.9 пунктээр өссөн байна.




2010 оны мөн үетэй харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн орлого 2015 оны эхний 10 сард 23.4 хувиар өссөн байхад энэ хугацаанд төсвийн зарлага 99.1 хувиар өссөн байна.


	2012 I-X/ 2010 I- X*100	2013 I-X/ 2010 I- X*100	2014 I-X/ 2010 I- X*100	2015 I-X/ 2010 I-X*100
Төсвийн орлого	118.5	123.9	121.5	123.4
Төсвийн зарлага	202.4	181.3	246.3	199.1

Эхний 10 сарын байдлаар улс болон орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийн төлөвлөгөөг Баруунтуруун сум 1.8, Давст сум 10.6, Өндөрхангай сум 5.9, Тариалан сум 0.3, Түргэн сум 36.6, Тэс сум 2.8, Ховд сум 5.4, Улаангом сум 13,2 хувиар тус тус тасалж бусад сумдууд 2.5- 50,5 хувиар давуулан биелүүллээ.

15.2 ОРОННУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 42.2 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь төлөвлөсөн хэмжээнээс 9.0 хувиар буюу 4.2 тэрбум төгрөгөөр дутуу байна. Нийт зарлагын 46.5 хувийг цалин хөлсөнд, 6.4 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 3.3 хувийг урсгал шилжүүлэгт, 14.0 хувийг халамжийн үйлчилгээнд, 29.0 хувийг бусад зардалд зориулан зарцууллаа.







Төсвийн зардлын 33.3 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 56.3 хувийг боловсрол, 9.8 хувийг эрүүл мэнд, спортын салбарт, 0.6 хувийг бусад салбарын үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.


15.3 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр энэ оны эхний 10 сард 573.0 сая төгрөгийн өртэй, 70.9 сая төгрөгийн авлагатай байна.



Төсөвт байгууллагын өглөг сүүлийн 3 жилийн дунджаас 215.9 сая төгрөгөөр буюу 60.5 хувиар илүү байна.

Төсөвт байгууллагын өглөг, 2014, 2015 оны саруудаар, сая төгрөг



10 дугаар сарын эцэст 45.3 сая төгрөгийн цалингийн, 30.1 сая төгрөгийн шимтгэлийн, 13.7 сая төгрөгийн гэрэл цахилгааны, 54.5 сая төгрөгийн түлш халаалтын, 13.0 сая төгрөгийн цэвэр бохир усны, 122,8 сая төгрөгийн тээвэр шатахууны, 48.9 сая төгрөгийн хоолны, 44.5 сая төгрөгийн эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслэлийн, 31.2 сая төгрөгийн албан томилолтын, 27.7 сая төгрөгийн байрны түрээсийн, 20.5 сая төгрөгийн шуудан холбооны, 68.8 сая төгрөгийн бусад зардлын өртэй байна.



XVI.ГАДААД ХУДААДАА

2015 оны эхний 10 сард импорт 20853.9 мян.ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2122.6 мян.ам доллараар буюу 9.2 хувиар өссөн байна. 21.9 мян.тн нефть бүтээгдэхүүн, 62213.0 мян.квт.цаг цахилгаан, 829 ш мебель тавилга, 1791.0 тн хивэг, 1457.9 тн овъёос, гурил 1875.0 тн, ачааны автомашин 8 ш, суудлын автомашин 25, хавтан хуванцар 805, тавилгын хавтан 2210.8 м2, модон хаалга 172 ш, ширмэн радиатор 18.9 тн, зулхай 300 м2, хаалганы хүрээ 448 ш, даавуун бүрээс 403.2 м2, шилмүүст модны банз 2377.4 м3, ган хоолой 2.1 тн, тавилгын холбох хэрэгсэл 2353 ш, хүнсний ногоо 19.8 тн, жимс жимсгэнэ 73.3 тн, чихэр 0.8 тн, ундаа 16.7 мян.л, жүүс 2.7 мян.л, гоймон 1.3 тн, ургамалын тос 0.1 мян.л, цагаан будаа 10.0 тн, өргөст хэмх 0.3 тн, хөц будаа 93 тн, өндөг 161.3 мян.ш, хийжүүлсэн ус 23.3 мян.л, тосгуур холигчийн хамт 24 ш, орны поролон 0.6 тн, сантехникийн холбох хэрэгсэл 0.5 тн, хуванцар түгжээ 35 ш, хуванцар цонх 1350, гутал хос 16 ш, 00 өрөөний суултуур 20, тоосго 133.1 тн, арвай 25 тн, төмөр хаалга 62 ширхэгийг тус тус импортоор оруулсан байна.



Өнгөрсөн оны мөн үеэс ачааны болон суудлын авто машин 25 ширхэгээр харин хивэг 2.6, овъёос 2.3, гурил 6.9, өндөг 2.4 дахин өссөн бол хөц будаа 29.2 авто бензин 48.9, дизель түлш 53.8, жимс жимсгэнэ 33.8 хувиар өссөн байна. Харин мебель тавилга 21.0 цахилгаан 23.9, хүнсний ногоо 65.0, чихэр 82.2, банз 55.7 хувиар тус тус буурсан байна.

2015 оны эхний 10 сарын байдлаар экспортонд 156.0 тн адууны мах, 6 ширхэг монгол гэр, чулуулгын дээж 390 кг гаргаж экспорт 303.8 мянган ам доллар болсон байна.



ХVIIҮНЭ

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 10-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 4.6, оны эхнээс 2.3, суурь оноос 58.5 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ,
ТАРИФЫН ИНДЕКС 10-р сарын 21 ний байдлаар

	$\frac{2015-10}{2010-12} \times 100$	$\frac{2015-10}{2014-10} \times 100$	$\frac{2015-10}{2014-12} \times 100$	$\frac{2015-10}{2015-09} \times 100$
ЕРӨНХИЙ ИНДЕКС	158.5	104.6	102.3	100.2
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	153.1	102.0	99.4	99.2
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	203.3	103.4	103.0	100.0
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	199.4	112.4	108.1	101.3
04. ОРОН СУУЦ, УС,ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	127.9	95.4	92.8	101.5
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	168.5	101.4	99.5	100.0
06. ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	164.9	110.7	106.8	99.5
07. ТЭЭВЭР	132.9	104.1	104.1	100.0
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	92.8	97.0	97.3	100.0
09. АМРАЛТ,ЧӨЛӨӨТ ЦАГ,СОЁЛЫН БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭ	122.1	107.4	107.4	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	223.2	110.6	110.6	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТ.БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	193.2	107.6	101.8	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	180.7	102.5	99.7	99.8

Өмнөх сараасаа хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.8, эм тариа,эмнэлгийн үйлчигээний бүлгийн үнэ 0.5, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувиар буурч орон сууц,түлш цахилгааны бүлгийн үнэ 1.5,хувцас ,бөс барааны бүлгийн үнэ 1.3 хувиар өсч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.




Өмнөх сараасаа 7 бүтээгдэхүүний үнэ 200-10000 төгрөгөөр өсч, 12 бүтээгдэхүүний үнэ 66-11666 төгрөгөөр буурсан байна.

Гол нэрийн барааны өсөлт,
бууралтын хувь

	ӨМНӨХ сараас	ӨОМҮГ-с
гурил дээд зэрэг	0.0	0.0
гурил, 1-р зэрэг	0.0	0.0
хонины мах	-10.0	-28.9
үхрийн мах	-10.0	-25.0
адууны мах	0.0	-18.2
ямааны мах	-12.5	-30.0
хиам	0.0	0.0
сүү	20.0	20.0
тараг	20.0	28.6
ургамлын тос	0.0	0.0
алим	0.0	0.0
мандарин	0.0	0.0
төмс	-20.0	0.0
байцай	-20.0	-7.7
лууван	-20.0	-7.7
манжин	-20.0	0.0
Бензин,А-80, 1 литр	0.0	0.0
Бензин,А-92, 1 литр	0.0	0.0
Дизелийн түлш, 1 литр	0.0	-0.2


Өнгөрсөн оны мөн үеэс байцай лууван 7.7, мах 18.2- 30.0 хувиар буурч сүү 20.0, тараг 28.6 хувиар өссөн байна.

Өмнөх сараасаа сүү, тараг тус тус 20.0 хувиар өсч, хүнсний



Сүүлийн 5 жилийн 10-р сарыг: - оны эхтэй харьцуулсан индексээс харахад 2014.10 сард хамгийн өндөр буюу 14.8 хувийн өсөлттэй, өмнөх сартай харьцуулсан индексээс харахад 2011 оны 10 сард хамгийн өндөр буюу 1.8 хувийн өсөлттэйгээр тооцогдож байна.

Сарын инфляцийн түвшин




Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, ундаа ус 2.0 %	Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь өссөн нь хүнсний ногооны бүлгийн үнэ 2.4, сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 3.5, чихрийн бүлгийн үнэ 2.9, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 52.4 хувиар өссөнтэй холбоотой байна.
Согтууруулах ундаа, тамхи 3.4 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 8.7 хувь өссөнтэй холбоотой байна.
Хувцас гутал бөс бараа, гутал 12.4 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 12.4 хувь өссөн нь хувцас, бөс барааны дэд бүлгийн үнэ 12.5, үүнээс бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 11.8 % , жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 34.7, гутлын дэд бүлгийн үнэ 12.2 хувь өссөнтэй холбоотой байна.
Орон сууц , ус -4.6 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувь буурсан нь орон сууцны засварын бүлгийн үнэ 0.1, түлшний бүлгийн үнэ 12.1 хувь буурсантай холбоотой байна.
Гэр ахуйн бараа, тавилга 1.4 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь өссөн нь гэрийн тавилганы дэд бүлгийн үнэ 4.0, гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл бүлгийн үнэ 14.8, гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг барааны дэд бүлгийн үнэ 3.4 хувь өссөнтэй холбоотой байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 10.7 %	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 10.7 хувь өссөн нь эм тариа эмнэлгийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 1.2, амбулаторийн үйлчилгээний үнэ 87.5, эмнэлэгт хэвтэж үйлчлүүлсэн үйлчилгээний үнэ 50.0 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр 4.1 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь өссөн нь хувийн тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 12.9, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн 0.6 хувь өссөнтэй холбоотой байна.
Холбооны үйлчилгээ -3.0 %	Холбооны үйлчилгээний үнэ тариф 3.0 хувиар буурсан нь гар утасны үнэ 25.9 хувиар буурсантай холбоотой байна.
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 7.4 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 7.4 % ном сонин бичгийн хэрэгслийн бүлгийн үнэ 12.8, дуу дүрс боловсруулах тоног төхөөрөмжийн бүлгийн үнэ 1.7 хувь өссөнтэй холбоотой байна.
Боловсролын үйлчилгээ 10.6 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.6 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 10.6 хувиар өссөнтэй холбоотой байна.
ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 7.6 %	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.6 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 9.1 хувь өссөнтэй холбоотой байна.
Бусад бараа үйлчилгээ 2.5 %	Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 % өссөн нь үсчин гоо сайхны үйлчилгээний үнэ 5.8 хувь, гоо сайхны хэрэгцээнд зориулсан эд зүйлсийн үнэ 2.2 - 17.2 хувь, монетон бөгжний үнэ 11.7 хувиар өссөнтэй холбоотой байна.


Өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна. 2015 оны 10-р сард Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 9 дүгээр сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.5 хувь өссөн байна. Өмнөх сарын дундаж үнээс хонины мах 12.8, үхрийн мах 13.5, ямааны мах 3.6 хувиар буурч, элсэн чихэр 2.4, сүү 19.7 хувиар өссөн байна.


Махны дундаж үнэ:

Хонь, үхрийн мах сарын турш тогтвортой 4500, ямааны мах сарын эхний гурван долоо хоногт тогтвортой 3500 төгрөг байгаад сарын сүүлийн долоо хоногт 500 төгрөгөөр буурсан байна.




10-р сард дунджаар 1 кг гурил 1100, хонины мах 4500, үхрийн мах 4500, ямааны мах 3375, 1 л шингэн сүү 1117, элсэн чихэр 1700, цагаан будаа 2300 төгрөгийн үнэтэй байсан байна.





Бензин, шатахууны үнэ сарын туршид тогтвортой байж өнгөрсөн оны мөн үеэс дизелийн түлш 0.2 хувиар буурч бусад нь өнгөрсөн оны түвшинд байлаа.



XVIII ХӨДӨӨ АЖ АХУЙ

18.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

Малын үнэ: 2015 оны 10 дугаар сард атны үнэ 875.0 ботгоноос бусад насны тэмээний үнэ 550.0– 800,0 мянга, унаганаас бусад насны адууны үнэ 450.0– 1000.0 мянга, тугалнаас бусад бүх насны үхрийн үнэ 391,0– 1000.0 мянга, бүх насны хонины үнэ 25.0 – 125.0 мянга, бүх насны ямааны үнэ 18.5 – 75.0 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.



Өмнөх сартай харьцуулахад атны үнэ 75.0 мянган төгрөг ингэний үнэ 50.0, гүүний үнэ 45.0, үнээний үнэ 33.0, хурганы үнэ 16.0, мянган төгрөгөөр өсөж бусад малын үнэ буурсан байна.



ХАА-н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох үхрийн шир 25000, адууны шир 25000, тэмээний шир 10000, хонины арьс 2000, ямааны арьс 6500, төгрөгийн дундаж үнэтэй байна.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн:

Улаанбуудай 1 тн нь 650.0, задгай өвс 1 тн нь 143.3, хужир шүү 1 тн нь 80.0, боодолтой өвс 5.7, түлээний мод м.куб нь 56.0, чацаргана 3.8, өргөст хэмх 3.5, сонгино 2.0 мянган төгрөгийн дундаж үнэтэй байна.







Үр тариа, төмс, хүнсний ногоо, байгалийн хадлан бэлтгэлт

Аймгийн хэмжээнд 3641.1 тн үр тариа 2768.5 тн төмс, 2652.4 тн хүнсний ногоо, 2267.7 тн тэжээлийн ургамал хураан авсан байна.

Хураан авсан үр тарианы 48.1 хувь нь Баруунтуруун суманд, төмсний 96,5 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан, Наранбулаг, Өмнөговь сумдад, хүнсний ногооны 94,6 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан, Наранбулаг сумдад тус тус ноогдож байна.

34,9 мянган тн байгалийн хадлан, 2267.7 тн тэжээлийн ургамал бэлтгэжээ. 20.8 мянган тн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14.8 мян.тн-оор бага байна.






XIX АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн чиглэлээр 108 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж оны эхний 10 сард оны үнээр 6.2 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 6.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт 2.7 хувиар буурч, бүтээгдэхүүний борлуулалт 13.4 хувиар өссөн байна.

**Нийт бүтээгдэхүүн, борлуулалтын орлого
/оны үнээр, сая төг/**



2010 оны зэрэгцүүлэх үнээр 4.0 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 11.6 хувиар буюу 524.8 сая төгрөгөөр буурч үүний дотор дулаан, усан хангамж түгээлт 15.5, уул уурхай олборлолт 42.1 хувиар өсч, боловсруулах үйлдвэрлэл 35.0 хувиар буурсан байна. Үйлдвэрлэлт сүүлийн 5 сар 4.2 – 11.6 хувиар буурсан нь иргэдийн худалдан авах чадвар муудсанаас бүтээгдэхүүн борлохгүй байгаа, мах бэлтгэл эхлээгүй, байна.


**Үйлдвэрлэлтийн өсөлт бууралт /сараар,
хувиар/**



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт


/сая.төг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, аймгийн

дүнгээр/




Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

/сая.төг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, салбараар/



Нийт үйлдвэрлэлтийн 45.6 хувийг дулаан түгээлт усан хангамж, 39.6 хувийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 14.8 хувийг уул уурхай олборлолт эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц




Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх, дулаан түгээлт усан хангамжийн салбар 17.4, уул уурхай олборлолтын салбар 2.8 пунктээр өсч, боловсруулах үйлдвэр 20.2 пунктээр тус тус буурсан байна.

Салбарын бүтэц

	2013 I-X	2014 I-X	2015 I-X
Дулаан түгээлт, усан хангамж	32.2	24.9	45.6
Уул уурхай олборлолт	7.5	9.4	14.8
Боловсруулах Үйлдвэрлэл	60.3	65.7	39.6
ДҮН	100.0	100.0	100.0

Дэд салбараар тооцвол нийт үйлдвэрлэлтийн 20.9 хувийг хүнс ундааны үйлдвэрлэлт, 43.5 хувийг дулаан үйлдвэрлэлт, 14.8 хувийг уул уурхайн олборлолт, 1.9 хувийг усан хангамж, 1.6 хувийг арьс шир, 0.8 хувийг мод модон бүтээгдэхүүн, 1.6 хувийг гутал арьс ширний үйлдвэрлэл, 0.1 хувийг хувцас үйлдвэрлэл, 1.2 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн бүтэц




Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 840 болж өнгөрсөн оны мөн үеэс 6.7 хувиар, 1 ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 21.8 хувиар өслөө.


Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ архи ундааны үйлдвэрлэл 2.5 дахин, нүүрс олборлолт 40.9, дулаан түгээлт 15.7, усан хангамж 11.3, гурил гурилан бүтээгдэхүүн 7.6 хувиар өсч, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.7, бусад боловсруулах бүтээгдэхүүн 13.2 / гэрийн шаахай, эсгий, гэрийн бүрээс/, арьс шир гутлын үйлдвэрлэл 25.7, сүү сүүн бүтээгдэхүүн 50.7, хувцас үйлдвэрлэл 82.4, өлөн боловсруулалт 95.6, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 96.4 хувиар тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг суурь он болох 2010 оны мөн үетэй харьцуулбал дулаан түгээлт 79.3, нүүрс олборлолт 51.0, түгээсэн цэвэр ус 24.6, нарийн боов 39.0, талх үйлдвэрлэл 24.3 хувиар өсч, өлөн боловсруулалт 96.0, архины үйлдвэрлэл 91.8 хувиар буурсан байна.


гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт
2010 I-X=100%/



Гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт
2010 I-X=100%



гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт
2010 I-X=100%



2010 оны мөн үеэс импортын цахилгаан 49.8 хувиар өссөн байна.




Аж ахуйн нэгжүүд 64 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч, 29 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 12 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэж байсан 15 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдээгүй байна.

зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
/биет хэмжээгээр/


		2011 I-X	2012 I-X	2013 I-X	2014 I-X	2015 I-X
дулаан	мянгал	47	83.2	79.6	88.0	98.6
нүүрс	тн	34.3	28.5	24.1	37.7	52.5
архи	мян л	512.8	295.5	25.1	11.1	83.0
ундаа	мян л	3.3	2.1	1.5	1.8	0
нарийн боов	тн	159.9	166.8	154.2	218.2	273.7
өлөн	мян гог	100.9	69.0	71.6	68.9	3
гурил	тн	392.0	297.7	331.5	199.2	83.0
чацарганы тос	кг	294.6	324.2	200.1	235.3	212
чацарганы ш/с	мян л	4.4	4.1	3.7	8.5	9.2
чацарганы сироп	мян л	10.1	18.8	19.1	27.3	62
талх	тн	77.8	78	101.7	67.7	141.9
хэрчсэн гурил	тн	37.2	38.1	12.1	4.0	3.7
хиам	тн	4.6	4	5.6	5.5	5.8
цэвэр ус т/гээлт	мян л	443.2	534.8	423.5	469.7	522.9
булигар	мян квм	1.8	1.5	2.1	0.9	0
шевро	мян квм	1	1.2	0.9	1.1	0
хөх шир	тн	0.5	1.1	1.3	0.4	0
гутал	хос	1032.0	1937.0	3821.0	3190.0	2946
тоосго	мян ш	2052.4	1965.0	2700.0	3370.0	2850.0
вакум цонх	кв м	219.9	519.0	290	742.0	69.0
замын хавтан	мян ш	40.0	57.0	37.5	25.5	45.0
дээврийн хавтан	кв м	3886.9	6022.8	8738.4	8648.7	2611.3

Өнгөрсөн оны мөн үеийн үйлдвэрлэлтээс хивэг 4.5д, варень 4.5д, архи 3.7д, чацарганы сироп 2.3д, арвайн гурил 2.1д, талх 2.1д, цэвэр ус үйлдвэрлэлт 2.0д, блок 97.2, гэрийн хаяавч 80.0, замын хавтаг 76.5, давс олборлолт 71.9, ажлын хувцас 59.1, пийшин 47.1, нүүрс олборлолт 40.4, нарийн боов 25.2, зайрмаг 18.6, гэрийн цагаан бүрээс 15.3, дулаан түгээлт 12.0 цэвэр ус түгээлт 11.3, чацарганы шүүс 8.2, хиам 5.5, хувиар өсч, өлөн боловсруулалт 95.6, сурагч форм 91.4, вакум цонх 90.5, тараг 85.9, зүсмэл 79.5, пальто 78.8, банш бууз 75.0, ор 71.4, дээврийн хавтан 69.8, сандал 63.3, хөөсөнцөр хавтан 63.0, тооно 62.5, эм хослол 55.2, гэрийн тавилга 48.1, хаалга 44.1, ширээ 42.9, хэрчсэн гурил 7.5, гоймон 2.5, бялуу 47.1, гурил 58.3, дээл 28.9, авдар 25.0, тоосго 15.4, гэрийн багана 12.5, морин хуур 11.8, чацарганы тос 9.9 гутал 7.6, хувиар буурсан байна.


**Зарим нэрийн бүтээгдэхүүний
үйлдвэрлэлт
/биет хэмжээгээр/**





Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/



Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/



**Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
/биет хэмжээгээр/**



Үндсэн үзүүлэлт

ХАВСРАЛТ

**АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД,
2015 ОНЫ ЭХНИЙ 1-10 САРД**

	2011 I-X	2012 I-X	2013 I-X	2014 I-X	2015 I-X
Төрсөн хүүхдийн тоо	1658	1762	1705	1797	1661
0- 5 насны хүүхдийн эндэгдэл, тоо	49	33	35	41	37
1000 амьд төрөлтөнд ноогдох	29.6	18.8	20.5	22.8	22.3
0-1 насны хүүхдийн эндэгдэл	41	26	30	33	32
1000 амьд төрөлтөнд ноогдох	24.7	14.8	17.6	18.4	19.3
Нас барсан хүний тоо	379	404	335	381	379
Халдварт өвчний гаралт	1011	552	426	430	473
10000 хүнд ноогдох халдварт өвчин	135	74	57.6	58.1	62.5
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	283	258	267	296	322
Хэрэглээний үнийн индекс, оны эхнээс, хувь	102.1	110.2	106.7	112.6	102.3
Хэрэглээний үнийн индекс, оны эхнээс, хувь	745	959	1161	834	1056
Банкны зээлийн үлдэгдэл, сая төг	62296.4	83121.9	126942.0	166241.4	161306.1
Үүнээс: хугацаа хэтэрсэн	211.3	209.7	418.1	1314.8	4288.1
Аймгийн төсвийн орлого, оны үнээр, сая төг	7030.0	7016.0	7338.3	7197.1	7307.2
Төсвийн зарлага, оны үнээр, сая төг	28523.3	42920.9	38440.6	52224.2	42215.0
Төсвийн өглөг, сая төг	416.6	412.5	338.6	320.2	573.0
Төсвийн өглөг, сая төг	8442.0	5642.4	5077.2	6398.2	6225.4
Төсвийн өглөг, сая төг	134.0	66.8	90.0	126.0	97.3
2010 оны төсвийн өглөг/зарлагын харьцаа	7235.3	4765.2	3562.8	4527.1	4002.2
Төсвийн өглөг, сая төг	329.0	276.1	232.1	364.0	517.1
Төсвийн зарлага, сая төг	6029.8	3043.7	1952.0	2621.6	1704.8
Төсвийн өглөг, сая төг	876.5	1445.4	1378.7	1541.5	1780.3
Төсвийн зарлага, сая төг	12179.4	13239.6	14276.9	10646.0	9062.0
Төсвийн зарлага, сая төг	7860.1	7574.4	8595.0	6438.5	3641.1
Төсвийн зарлага, сая төг	2573.8	3074.9	2821.5	2088.3	2768.5
Төсвийн зарлага, сая төг	1745.5	2590.3	2860.4	2119.2	2652.4

Сумдын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, 2015 оны эхний 10 сар

(Сумдаар)

	Гэмт хэрэг		Хүн амын төрөлт	Хүн амын нас баралт	Халдварт өвчний гаралт	10,0 мянган хүнд ноогдох халдварт өвчний гаралт	0-5 насны хүүхдийн эндэгдэл	1000 амьд төрөлтөнд ноогдох	Бүртгэлтэй ажилгүй чүүдийн тоо
	тоо	10000 хүнд ноогдох							
Баруунтуруун	7	46	34	15	2	8.2	1	29.4	17
Бөхмөрөн	8	63	5	8	9	43.0	1	200.0	43
Давст	11	112	2	8	8	51.0	0	0.0	90
Завхан	2	20	11	10	2	11.5	0	0.0	11
Зүүнговь	6	41	7	12	6	22.7	2	285.7	20
Зүүнхангай	6	46	11	10	12	57.0	1	90.9	63
Малчин	11	81	14	10	13	55.3	0	0.0	12
Наранбулаг	8	34	9	19	10	24.8	1	111.1	42
Өлгий	109	85	8	16	2	9.3	0	0.0	29
Өмнөговь	7	37	59	25	10	23.9	0	0.0	19
Өндөрхангай	6	37	32	16	7	23.1	2	62.5	13
Сагил	9	48	6	5	9	40.9	0	0.0	48
Тариалан	14	47	38	20	25	67.3	2	52.6	52
Түргэн	14	114	4	6	23	114.0	1	250.0	31
Тэс	7	47	28	15	23	45.5	3	107.1	34
Ховд	10	55	17	13	7	31.3	1	58.8	17
Хяргас	19	75	27	9	7	30.3	0	0.0	20
Цагаанхайрхан	158	159	13	8	5	24.9	0	0.0	23
Улаангом		91	1336	154	293	105.2	22	16.5	472
Бүгд	322	71	1661	379	473	62.5	37	22.3	1056
2014 I-X	296	66	1797	381	430	58.2	41	22.8	834